



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН  
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар *А/92*

Улаанбаатар хот

Журам батлах тухай

“Дээд боловсролын тухай хууль”-ийн 31.1.2, “ҮБХИС-ийн дүрэм”-ийн 11.7.1, 11.7.7, ҮБХИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2024 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны 01 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Олон улсын мэргэжлийн сэтгүүлд бүтээл хэвлүүлсэн багш, судлаачдад судалгааны ажлын зардал олгох журам”-ыг хавсралтын ёсоор баталсугай.
2. Журмыг 2024 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит чанарын үнэлгээний алба / дэд хурандаа Э.Баттөр/-нд үүрэг болгосугай.


ЗАХИРАЛ  
БРИГАДЫН ГЕНЕРАЛ



П.ЖАРГАЛАН

Боловсруулсан:..... *Д. Энхчимэг* ..... Д.Энхчимэг  
Хянасан:хур..... *Б.Өлзийхуяг* ..... хур Б.Өлзийхуяг  
Хувь:01

ҮБХИС-ийн захирлын 2024 оны  
... дүгээр сарын ... өдрийн ...  
... дугаар тушаалын хавсралт



**ОЛОН УЛСЫН МЭРГЭЖЛИЙН СЭТГҮҮЛД БҮТЭЭЛ ХЭВЛҮҮЛСЭН БАГШ,  
СУДЛААЧДАД СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗАРДАЛ ОЛГОХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Монгол Улсын Боловсролын багц хуулиуд, Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм, “ҮБХИС-ийг хөгжүүлэх стратеги-2030” баримт бичгийг хэрэгжүүлэх хүрээнд судлаач багш нарын судалгааны ажлыг дэмжих, олон улсын хэмжээнд эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлэхэд шаардлагатай санхүүжилт (цаашид “судалгааны санхүүжилт”) -ийн асуудлыг зохицуулахад энэхүү журмын (цаашид “журам” гэх) зорилго оршино.

1.2. Судалгааны санхүүжилт нь байгалийн ухаан, инженер технологи, нийгмийн ухаан, хүмүүнлэгийн салбарууд болон ҮБХИС-д хэрэгжүүлж буй батлан хамгаалах судлал, цэргийн шинжлэх ухаан, аюулгүй байдал судлалын чиглэлээр судалгааны ажлынхаа үр дүнг олон улсын мэдээллийн санд бүртгэлтэй, хянан магадлагаа хийгддэг шинжлэх ухааны болон мэргэжлийн сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлэхэд багш, судлаач, докторант, магистрантуудын зардлын тодорхой хувийг олгоход зориулагдана.

1.3. Энэхүү журам нь ҮБХИС-ийн судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийн агуулгын хүрээнд эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг дээшлүүлэх, багш, судлаачдын тоог нэмэгдүүлэх, судалгаа хөгжүүлэлтийн ажлыг дэмжихэд чиглэгдэнэ.

**Хоёр. Судалгааны санхүүжилтийг олгох болзол, нөхцөл**

2.1. ҮБХИС-ийн багш, судлаач, докторант, магистрант нь дараах олон улсын мэдээллийн санд бүртгэлтэй, хянан магадлагаа хийгддэг шинжлэх ухааны болон мэргэжлийн сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн байна. Үүнд:

2.1.1. Олон улсын шинжлэх ухааны мэдээллийн санд (Web of Science, Scopus)-т бүртгэлтэй хөндлөнгийн хянан магадлагаа хийгдсэн мэргэжлийн сэтгүүл;

2.1.2 Олон улсын бусад мэдээллийн санд бүртгэлтэй, хянан магадлагаа хийгддэг Q1-Q4 зэргийн (Google Scholar, Semantic Scholar, Pubmed, International ranked journals with High impact factor /iF-JSR, GSJ/) мэргэжлийн сэтгүүл байна.

2.2. ҮБХИС-ийн багш, судлаач, докторант, магистрант нар нь 2.1-д заасан сэтгүүлд нэгээс дээш хүний бүрэлдэхүүнтэйгээр эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлж болно. Энэ тохиолдолд судалгааны санхүүжилтийг нэг хүнд тооцож олгоно.

2.3. ҮБХИС-ийн багш, судлаач, докторант, магистрант нь 2.1-д заасан сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн (хэвлэхээр зөвшөөрөгдсөн өгүүллийг тооцож болно) байх шаардлагатай.

2.4. 2.1-д заасан сэтгүүлд 1 жилд нийтлүүлэх өгүүллийн тоог хязгаарлахгүй.

2.5. ЭШИХ нь 2.1-д заасан сэтгүүлд нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүллийн талаарх мэдээллийг мэдээллийн санд оруулж, нийтийн хүртээл болгох асуудлыг хариуцна.

2.6. ҮБХИС-ийн судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийн агуулгад нийцсэн өгүүлэл байна. Тухайн өгүүллийн агуулгын хүрээнд судалгааны ажлын ёс зүйг баримталж хариуцлагыг зохиогч өөрөө хариуцна.

2.7. Бусад эрдэм шинжилгээний байгууллагатай, эрдэмтэн судлаач багштай хамтын бүтээл хэвлүүлсэн тохиолдолд зөвхөн нэгдүгээр болон холбоо баригч зохиогчид судалгааны ажлын санхүүжилтийг олгоно.

2.8. Эрдэм шинжилгээний өгүүллийг ҮБХИС-ийн нэр дээр олон улсын тухайн мэргэжлийн сэтгүүлд нийтлүүлсэн байна.

### **Гурав. Судалгааны санхүүжилт олгох**

3.1. ҮБХИС-ийн багш, судлаач, докторант, магистрант нь эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн баримт, нотолгоог Эрдэм шинжилгээ инновацийн хэлтэс хянан магадалж санхүүжилт олгох саналыг холбогдох удирдлагын бүрэлдэхүүнд уламжилна.

3.2. Эрдэм шинжилгээ инновацийн хэлтэсийн саналыг ҮБХИС-ийн эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал хянаж, их сургуулийн захиралд уламжилна.

3.4. ҮБХИС-ийн захирал нь судалгааны санхүүжилт олгох чиглэлээр холбогдох нотлох баримтад тулгуурлан дараах шийдвэрийг гаргана. Үүнд:

3.4.1. Олон улсын шинжлэх ухааны мэдээллийн санд бүртгэлтэй хөндлөнгийн хянан магадлагаа хийгддэг мэргэжлийн сэтгүүл (Web of Science, Scopus)-д нэгдүгээр зохиогч эсвэл холбоо баригчаар эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн бол нийт зардлын 50 хувь;

3.4.2. Тухайн мэргэжлийн чиглэлээр хянан магадлагаа хийгддэг олон улсын мэдээллийн санд бүртгэлтэй мэргэжлийн сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн бол нийт зардлын 40 хувь тус тус олгоно.

3.4.3. Тухайн сэтгүүлийн хэвлэл редакцийн зөвлөлөөр хянагдаж хэвлүүлэхийг зөвшөөрсөн мэдэгдэх хуудас, өгүүлэл хэвлүүлэхтэй холбогдсон төлбөрийн хүсэлтийн нэхэмжлэх электрон шуудангаар ирсэн тохиолдолд судалгааны ажлын санхүүжилтийг тухайн гадаадын байгууллага уруу шилжүүлнэ.

### **Дөрөв. Судалгааны санхүүжилтэд хяналт тавих**

4.1. ҮБХИС-ийн багш, судлаач, докторант, магистрант нь судалгааны санхүүжилтийн тайланг Эрдэм шинжилгээ, инновацийн хэлтэс, Санхүүгийн хэлтэст гаргаж өгнө.

4.2. Журмын хэрэгжилтэд ҮБХИС-ийн Дотоод аудит, чанарын үнэлгээний алба хяналт тавьж ажиллана.

\*\*\*\*\*